



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/279

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйл, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа болон шинээр барьсан, өргөтгөл шинэчлэлт хийсэн барилга, байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах үйл ажиллагааны зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ж.Сайнцог

-Аймгийн Засаг даргын Хөгжлийн Бодлого хариуцсан орлогч дарга

Гишүүд:

Б.Отгонбаасан

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Хангал

-Аймгийн ерөнхий архитектор бөгөөд Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Б.Гэрэлмаа

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техник хяналтын Улсын байцаагч

З.Билэгсайхан

-“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын хяналтын инженер

А.Оюунчимэг

-Эрчим хүчний зөвлөх инженер

З.Энхжаргал

-Барилгын мэргэшсэн инженер

2. Мэргэжлийн байгууллагаар барилга, байгууламжийн бат бэх, аюулгүй байдалд дүгнэлт гаргуулж паспортжуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг үйл ажиллагааг зогсоож дахин төлөвлөлтөд оруулах тухай санал бэлтгэн танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Ж.Сайнцог/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

